

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР


ДҮҮРГИЙН УДИРДЛАГУУД БОЛОН АЛБАН ТУШААЛТНУУДЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН- /ӨССӨН ДҮНГЭЭР/

2021 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны А/208 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 2020-2024 онд хийж хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиглэлээр төлөвлөж байгаа ажлын тайланг танилцуулах, хийж хэрэгжүүлсэн ажлаа иргэдэд тайлагнах, сурталчлах цахим уулзалтыг 25 хороонд зохион байгуулж 121000 орчим иргэд оролцсон.

Баянгол дүүргээс сонгогдсон Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Дүүргийн удирдлагууд, 25 хороодын Засаг дарга нар, үндсэн болон харьяа хэлтэс, албадын дарга нар бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон.



Уулзалтад оролцогчдын санал сэтгэгдлийг нь сонсож, шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдол санал хүсэлтийг чиг үүргийн дагуу холбогдох мэргэжилтнүүд тухай бүр шийдвэрлэн хариу өгч ажилласан. Мөн иргэдээс гаргасан санал санаачилгыг дүүрэг, хороодын Засаг дарга нар 2022 оны жилийн зорилт, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Засаг дарга болон дүүргийн удирдлагуудын иргэдтэй уулзах уулзалтыг хуваарийн дагуу зохион байгуулан 24 иргэнийг хүлээн авч уулзаж санал бодлоо солилцсон. Уулзалтаар шууд шийдвэрлэх боломжтой асуудлыг холбогдох мэргэжилтнүүдийг байлцуулан тухай бүр шийдвэрлэн, судалж үзэх шаардлагатай санал хүсэлтийг цахим програмд бүртгэж холбогдох хариуг хуулийн хугацаанд өгч ажилласан.

Уулзалтад хамрагдсан иргэдийн асуудлыг хандалтаар нь авч үзвэл эмчилгээний мөнгөн тусламж хүссэн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар 26%-ийг эзэлж байна.

Засаг дарга болон Дүүргийн удирдлагууд иргэдтэй хийсэн уулзалтаар ирүүлсэн иргэдийн санал хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 22 цаг 56 минут байна

Иргэдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ тэднээс гаргасан шинэ санал санаачилгыг дэмжин ажиллаж дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан.

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжин амьжиргааны түвшинг дээшлүүлэн, ажлын байраар ханган ажиллах зорилгоор “Баянгол Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес эрхлэх төв”-ийг 23 дугаар хороонд шинээр байгуулж 3 иргэнийг оёдлын үйлдвэрт зуучилж ажлын байраар хангасан.

2.Төрийн одон медалиар шагнуулах хүсэлт гаргасан иргэдэд бүрдүүлэх материалын талаар мэдээлэл өгч журмыг танилцуулан, эмчилгээний болон мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 13 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн.

2.Иргэдэд үйлчлэх төв нь 1800-1222 тусгай дугаарын утсаар 8263 дуудлагыг хүлээн авч хууль эрх зүй, нийгмийн даатгал халамжийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч 73 иргэнийг ажлын байранд зуучилсан.

Засаг дарга болон Дүүргийн удирдлагуудын иргэдтэй хийсэн уулзалтын мэдээг улирал бүр www.bgd.mn цахим хуудсаар мэдээлж ажиллалаа.

ХЯНАСАН:

4ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНГӨНХУЯГ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ГЭРЭЛЭЭ